



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
Б.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.05.08 № 01/3791
танай 2019.04.23-ны № 01/1899

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Архитын Буяннэмэхийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй болно.


Нэр дэвшигч нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн нэр дэвшигч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

Мөн нэр дэвшигч А.Буяннэмэх нь 2006 оны 04 дүгээр сараас хүнс барааны бөөний худалдаа, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулах “Үлэмжийн дэсгэт” ХХК, 2010 оны 11 дүгээр сараас бизнесийн зөвлөгөө өгөх, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулах “Тэгш долоон тэнгэр” ХХК, 2016 оны 08 дугаар сараас онлайн худалдаа, гадаад худалдаа, бизнесийн зөвлөгөө өгөх, хүнсний дэлгүүр, зар сурталчилгаа хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулах “Ерхөг арвай үндэсний сүлжээ” ХХК-ийн захирлаар тус тус бүртгэлтэй байх тул дээрх хуулийн 19 дүгээр зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журмыг баримталж ажиллах нь зүйтэй.

Хүндэтгэсэн,

ДАРГА



З.ДАШДАВАА

00000003